

БАТЛАВ: ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА:(Г.ЭНХМӨНХ)

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“СМАРТ ЭКО ТРАНС” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ (Б.БАТНАСАН)

“СМАРТ ЭКО ТРАНС” ХХК
АВТОМАТ УДИРДЛАГАТАЙ ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ТЕРМИНАЛ БАЙГУУЛАХ
ТӨСӨЛ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ “СМАРТ
ЭКО ТРАНС” ХХК-ИЙН “АВТОМАТ УДИРДЛАГАТАЙ ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН
ТЕРМИНАЛ”-ЫН ТАЛБАЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ
(АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6677678)

ХЯНАСАН:

.....: (.....)

БОЛОВСРУУЛСАН:

“СМАРТ ЭКО ТРАНС” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН: (Ж.МАЙРА)

Гарчиг

1. Төслийн товч танилцуулга:	1
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	2-4
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	4
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	5

Хүснэгтийн жагсаалт

1. Хүснэгт 1. Смарт эко транс (ХХК)-ийн мэдээлэл	2
2. Хүснэгт 1. “Смарт эко транс” ХХК-ийн холбогдох албан тушаалтануудын мэдээлэл	2
3. Хүснэгт 2. 2026 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл	6
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7-9
6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	9-10
7. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	10
8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	11-12
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	13-14
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15-16
11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	16-17
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар	17

Зургын жагсаалт


1. Зураг 1. “Смарт эко транс” ХХК-ийн Автомат удирдлагатай терминал чингэлэг тээврийн терминалын талбайн байришил	1
2. Зураг 2. Смарт эко транс ХХК-ийн Автомат удирдлагатай терминал чингэлэг тээврийн терминалын талбайн газар ашиглалт	3

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Төслийн үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харьяалал.

Ханбогд сум нь 15,150 орчим км² нутагтай, Номгон, Гавилууд, Жавхлант, Баян Хайрхан гэсэн 5 багтай. Тус сумын нутагт Галбын говь байдаг монгол улсдаа тэмээнийхээ тоогоор 1-рт ордог. Галбын улаан угшлын тэмээг өсгөдөг. Даланзадгад хотоос 294 км, нийслэл Улаанбаатараас 650 км-ийн зайд оршино. Төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон хилийн боомт орчимд байрлах тул хүн амын нягтшил багатай, эргэн тойронд малчин айл өрх байхгүй бөгөөд талбайгаас хойшоо буюу Номгон багийн нутаг дэвсгэрт тархмал байдлаар суурьшина.

Төслийн байршил: Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон 1-р багийн нутаг дэвсгэрт Гашуун сухайтын хилийн боомтод оршино.



Зураг 1. “Смарт эко транс” ХХК-ийн Автомат удирдлагатай терминал чингэлэг тээврийн терминалын талбайн байршил

Хүснэгт 1. Сمارт эко транс (ХХК)-ийн мэдээлэл

Аж ахуй нэгжийн нэр	Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Смарт эко транс ХХК – ийн хаяг, байршил
Смарт эко транс (ХХК)	6777678	Тээвэр логистик	

Хүснэгт 1. “Смарт эко транс” ХХК-ийн холбогдох албан тушаалтануудын мэдээлэл

№	Албан тушаал	Нэр
1	Гүйцэтгэх захирал захирал	Б.Батнасан
2	Захиргаа, хүний нөөцийн албаны дарга	Батцэцэг
3	Байгаль орчны мэргэжилтэн	Ж.Майра

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газарзүйн мужлал: Төслийн талбай нь физик газарзүйн мужлалаар Говийн их болон Дорнод говийн мужийн Сулинхээр-Замын Үүдийн талархаг тойрогт хамаарах ба Байгалийн бүс бүслүүрээр Цөлийн бүсийн Жинхэнэ цөлийн бүслүүрт хамрагдаж байна. Нутаг дэвсгэрийн ерөнхий шинж нь нам уулс, жижиг толгод бүхий гүвээрхэг, долгиорхог өргөн тал хөндийн ерөнхий шинжийг хадгална.

Уур амьсгал: Уур амьсгалын мужлалын хувьд ерөнхийдөө гандуу дулаан зун, хүйтэн өвөлтэй, өвөл зуны температурын ялгаа ихтэй, хур тунадасны хувьд бага, татруу уур амьсгалтай. Зуны улиралд халуун хуурай, өвлийн улиралд дулаан, хавар болон намрын улиралд шороон болон цасан шуургатай өдөр олон тохиолдоно. Ханбогд сумын нутагт нарны нийлбэр цацрагийн жилийн дундаж 1500 квт ц/м²-аас их, нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа жилд дунджаар 3400 цагаас их, сард 283 цагаас их, хоногт 11.8 цагаас их байдаг байна. Судалгаанд хамрагдаж буй газар нутгаар агаарын температурын олон жилийн дундаж 7.4⁰C болно. Жилд дунджаар нэн халуун буюу агаарын температур 30⁰C-ээс дээш өдрийн тоо 42 өдөр ажиглагда на. Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур 8.8⁰C байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг градусаас доошилдог.

Агаарын чанар: Өмнөговь аймаг нь хур тунадас бага, хуурай уур амьсгалтай нутаг бөгөөд сүүлийн жилүүдэд тус аймагт уул уурхайн салбар эрчимтэй хөгжихийн хирээр тоосжилт ихээр бий болж байгаа бөгөөд энэ нь уурхайн үйл ажиллагаа, тээвэрлэлтийн замуудтай шууд холбоотой гэж үздэг. Мөн сүүлийн жилүүдэд аймгийн нийт нутгаар хур бороо хомс, өвс ургамлын гарц муу байсан нь хөрс ихээр хуурайшиж тоос босох нэг нөхцөл болж байна.

Гадаргын ус: Ус зүйн мужлалаар Төв Азийн гадагш урсацгүй ай савын түр урсгал бүхий гол горхины мужид хамаарах ба гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, байнгын урсацтай гол горхи байхгүйгээс ус зүйн хувьд төдийлөн сайн судлагдаагүй. Монгол орны усны сав газраар Галба-Өөш Долоодын говь гэсэн ай савд хамаарагдана. Энэ бүс нутгийн олон жилийн дундаж урсац буюу модуль нь км²-д 0.5-0.1 л/с. Гадаргын урсац 5 мм, газар нутгийн нийт чийгшил 50-100 мм, голын сүлжээний нягтшил 0.01-0.05 км/км², гол мөрний нийлбэр урсац 0.5-1 л/с-км², усны гадаргаас уурших ууршилт 5-9 дугаар сард 900-1100 мм байна.

Газрын доорх ус: Өмнийн говийн тал болон хагас цөлөрхөг хуурай уур амьсгалтай геологийн нийлмэл тогтоцтой, ан цав багатай дүүрэг нь газар доорх ус бүрэлдэх хангалттай нөхцөл болж чаддаггүй тул газар доорх усны олон тооны жижиг бассейн, линз, давхаргууд үүсгэдэг бөгөөд давсархаг эсвэл давст устай байдаг. Төслийн талбай орчмын газрын доорх усны ашиглаж болох боломжит нөөцийн зургаас харахад бага нөөц баялагтай (0.03-0.3 л/с) нүх сүв, ан цавын чөлөөт болон дарагдмал гадаргад ус тархсан ба газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөц нь < 5 мм/жил/км²

бага байна.


Хөрс: Хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Говийн мужийн өргөргийн бүсшилийн цөлийн бор саарал хөрсний Галбын говийн тойрогт хамрагдана. Нам уулс, толгодын хэсгээр дутуу хөгжилтэй сайр чулуурхаг цөлийн бор саарал (гөлтгөнөгүй), тал хөндий, нам хотос хэсгээр цөлийн бор саарал, цөлийн мараалаг бор саарал, уугуул хэлбэрийн мараа хөрс, элсэн хөрс голлон тархана.

Ургамал: Ургамал-газарзүйн мужлалаар Тал талархуу газрын Төв Азийн бүсийн Галбын говийн (цөлийн) тойрогт хамаарагдах бөгөөд бүхэлдээ жинхэнэ цөлийн хэв шинжийг илэрхийлэгч сөөг болон хагас сөөгөнцөр ургамал зонхилон тархсан.

Амьтан: Амьтны аймгийн газарзүйн мужлалын хувьд Умард говийн болон Алтайн өвөр говийн тойрогт хамаарах (А.Г.Банников 1954) бөгөөд говь цөлийн амьтад тэргүүлж мэргэгчдээс чичүүл, савагдаахай, загийн шар чичүүл, говийн алаг даага, бор зусаг, туурайтнаас хар сүүлт, хулан, янгир, аргаль, махчин амьтдаас чоно, үнэг зонхилно. Цөлийн экосистем тул амьдрах орчны элдэв хэв шинж цөөн илрэх бөгөөд бүхэлдээ нэг хэвийн амьдрах орчин

Сумын газар нутгийн нийт хэмжээ 1,266,061.00 га. Газрын нэгдмэл сангийн ангиллаар нь хувааж үзвэл:

- Хөдөө аж ахуйн эдэлбэр газар-1,128,075.02 га
- Хот тосгоны эдэлбэр газар-9,546 га
- Усны эдэлбэр газар-1,661.00 га
- Тусгай хамгаалалттай газар-84,146 га
- Зам, шугам сүлжээний газар-45,80 га байна.



Зураг 2. Смарт эко транс ХХК-ийн Автомат удирдлагатай терминал чингэлэг тээврийн терминалын талбайн газар ашиглалт

Нийгэм, эдийн засгийн байдал: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт орших Цагаан хад суурьшлын бүс нь Гашуун сухайтын хилийн боомтын ойролцоо байрладаг бөгөөд 1992 онд боомт нээгдсэнээс хойш энд хүн амын төвлөрөл бий болжээ. □ **Хүн амын өсөлт:** Уул уурхайн бүсийн төв учир шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, хүн амын тоо тогтвортой өсөх хандлагатай.

- **Ажил эрхлэлт:** Уул уурхайн салбар давамгайлж, үйлчилгээ, худалдаа, барилга, тээврийн салбар дагалдан хөгжиж байна.
- **Амьжиргааны түвшин:** Хүний хөгжлийн индекс аймгийн дундажтай ойролцоо, уул уурхайн орлогоос хамааран дундаж орлого өндөр.
- **Орон нутгийн төсөв:** Уул уурхайн татвар, төлбөрөөс хамааран төсөв нэмэгдэж, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний хөрөнгө оруулалт өссөн. Хөгжлийн төлөвлөгөө (2025–2026)
- **Хөрөнгө оруулалт:** 825.9 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжиж, хот төлөвлөлт, дэд бүтэц, ногоон хөгжлийн чиглэлд зарцуулагдаж байна.
- **Хот төлөвлөлт:** 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөнд ухаалаг, ногоон, тогтвортой хөгжлийн зарчим тусгагдсан.
- **Дэд бүтэц:** Зам, цахилгаан, усан хангамж, бохир усны системийг шинэчлэх, өргөтгөх ажлууд хийгдэж байна.
- **Нийгмийн үйлчилгээ:** Сургууль, эмнэлэг, соёлын төвүүдийг өргөтгөх, шинэчлэхээр төлөвлөсөн.

Сумын ИТХ ба бодлого

- **2024–2028 оны бүрэн эрхийн хугацаанд** сумын ИТХ орон нутгийн хөгжлийн бодлого, төсөв, багийн бүтцийн өөрчлөлтийг хэлэлцэж, хэрэгжүүлж байна.
- **Орон нутгийн оролцоо:** Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар багийн бүтцийн шинэчлэл, төсөв хуваарилалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэж байна.

Давуу тал ба сорилтууд

Давуу тал:

- Уул уурхайн томоохон төсөлтэй холбоотой тогтвортой хөрөнгө оруулалт.
- Дэд бүтцийн шинэчлэл, орон нутгийн төсөв нэмэгдсэн.
- Ажил эрхлэлтийн боломж өргөжсөн.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгасан. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг тусгасан болно

Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх

Төслийн талбай нь Говийн бага ДЦГ-ын “Б” хэсгийн хязгаарлалтын бүстэй давхцалтай байгаа хэдий ч Гашуунсухайтын хилийн боомт орчимд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай автомат удирдлагатай нүүрсний чингэлэг тээврийн терминал байгуулах шийдвэрийг Монгол улсын Засгийн газраас гаргасан. Үүний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Говийн бага ДЦГ-ын хамгаалалтын захиргаа, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудаас зохих зөвшөөрлийг авсаны үндсэн дээр улсын тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төслийн гол зорилт

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дугаар сарын 14-ний өдрийн “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах тухай” 349 дугаар тогтоолоор КОВИД- 19 цар тахлын үед экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нүүрсний экспорт бүхий хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад автомат удирдлагатай чингэлэгт тээврийн терминал байгуулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг нүүрс олборлон экспортолж буй аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгэхээр шийдвэрлэсэн байна.

Тус шийдвэрийн хүрээнд Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулахтай холбоотой санхүүжилтийн нийт зардлыг “Смарт эко транс” ХХК хариуцан санхүүжүүлэхээр тохиролцсон байна.

Уг Чингэлгийн тээврээр нүүрс тээвэрлэх, хадгалах, ачиж буулгах зэрэг үйл ажиллагаанд үүсэх хорогдлыг бууруулах, нүүрсний чанар алдагдуулахгүйгээр байгаль орчин, жолооч нарт ээлтэй, эдийн засгийн үр ашигтай экспортын хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг уламжлалт тээвэр нөлөөллийг бууруулахад ихээхэн хувь нэмэр үзүүлж байна.

Ганц мод/Гашуунсухайт боомтын байгаль, орчны нөхцөлд нийцүүлэн, тухайн боомтын нүүрс тээвэрлэх үйл ажиллагаанд чиглэн, хоёр улсын холбогдох яамдын захиргааны шаардлагын дагуу аюулгүй, өндөр үр ашигтай, бага зардалтай нүүрсний хил нэвтрэх тээврийг зохион байгуулж, аюулгүй ажиллагаа болон хууль дүрэмд нийцүүлэн ачаа нэвтрэх үйл ажиллагааг зогсолтгүй сайжруулан, тээврийн бүтээмжийг нэмэгдүүлж, боломжит нөхцөлд 24 цагийн турш тасралтгүй тээвэр хийнэ.

Төслийн байршил: Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон 1-р багийн нутаг дэвсгэрт Гашуунсухайтын хилийн боомтод оршино.

Төсөл хэрэгжсэнээр:

- 4.1.1. Таван толгой бүлэг ордын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн ачих нүүрс гүний гаалийн бүрдүүлэлт хийгдэж, нүүрстэй чингэлэг (нэгж чингэлэгт 32.5 тонн) ачсан тээврийн хэрэгсэл Гашуун сухайт боомт руу тээвэрлэх;
- 4.1.2. Монгол талаас нүүрстэй чингэлэг (нэгж чингэлэгт 32.5 тонн) тээвэрлэгдэж ирээд гаалийн талбай дээр бууж, хоосон чингэлэг ачиж буцах;
- 4.1.3. Хятад талаас өдрийн цагаар (08:00-20:00) хоосон чингэлэгтэй тээврийн хэрэгсэл нэвтэрч, нүүрстэй чингэлэг ачигдаж экспортод гарах;
- 4.1.4. Давхар чиргүүлтэй нэг тээврийн хэрэгсэл нийт 4 нүүрстэй чингэлэг буюу 128 тонн нүүрс тээвэрлэх боломжтой;
- 4.1.5. Давхар чиргүүлтэй 500 тээврийн хэрэгсэл гарах тохиолдолд өдөртөө 2,000 чингэлгээр нийт 64,000 тн экспортлох боломжтой;
- 4.1.6. Гашуун сухайт боомт нь жилдээ 300 хоног ажиллахад 19.2 сая тонн нүүрс чингэлэг тээврээр экспортлогдоно гэж үзэж байна.

Хүснэгт 2. 2026 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний төсвийн нэгтгэл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2026 оны төсөв
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	2,170,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,800,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	1,000,000
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,500,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2,100,000
8	Нөлөөллийн бүсийн оршн суугчидад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт дүн		9,570,000

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Чингэлэг ачиж буулгах, тээвэрлэх үйл ажиллагааны үед тоосжилт үүсэх	Машины хурдны хязгаарт хяналт тавих тэмдэг, тэмдгэлгээг байршуулах	Терминалын талбайд ажиллаж буй техник хэрэгсэл	ш	1	120.0	120.0	2026 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016
2	Машин техникийн түлшний дутуу шаталтаас бохирдуулагч хий ялгарах	Дизель хөдөлгүүртэй техникт утааны шүүлтүүр суурилуулах	Терминалын талбай	ш	Үйл ажиллагааны зардал		2026 он		
3		Байгууллагын машин техникийг техникийн улсын үзлэгт оруулах	Терминалын талбай	удаа	Үйл ажиллагааны зардал		2026 он		
Дүн							120.0		
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
4	Ундны усны чанар стандартад нийцэхгүйгээс болж, ажилчид өөрчлөх	Худгийн бүрэн бүтэн байдлыг байнга хянах, дээж авч байх	Унд ахуйн болон технологийн хэрэгцээнд ашиглах худгууд	ОХШ хөтөлбөрт тусгасан			2026 он	Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	
5	Газрын доор усны нөөц хомсдох, ус ашиглуулах дүгнэлтэд тусгагдсан хэмжээнээс хэтрүүлэн ашиглах	Усны тоолуур суурилуулах	Гүний худгууд	ширхэг	3	350.0	1,050,000		2026 он

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
6	Усны нөөц хомсдох	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Терминалын талбай	удаа	Үйл ажиллагааны зардал			2026 он	
Дүн							1,170,000		
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
7	Хөрсний бохирдол	Асгаралтын шингээгч бодис / spill kit/-н бодис бэлэн байлгах, шаардлагатай газарт байршуулах	Засварын талбай, түлш цэнэглэх талбай	ширхэг	1	1,000,0	1,000,0	2026 он	MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”
Дүн							1,000,000		
Ургамал, биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
8	Терминалын талбайн шимт хөрсийг хуулснаас ургамалан нөмрөг, мод, бут нөлөөлөлд өртөх	мод сөөг тарьж ургуулах, арчилгаа тордолгоо, мониторинг хийх	Терминалын талбай	М.квадрат	160	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зардалд тусгагдсан		2026 он	Нөхөн сэргээлтийн аргачлал Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай MNS 4585:2016
Бусад, байгалийн гамшиг, аваар осол, эрсдлээс урьдчилан сэргийлэх									

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
9	Осол гэмтэл, байгалийн гамшигт үзэгдэл, тоног төхөөрөмжийн саатал зэрэгт ажиллагсад өртөх, хариу арга хэмжээ авч чадаагүйгээс үүдэн эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрах	Бүх ажилчидад ХАБЭА-н болон галын аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах, өдөр бүр ажилчидад ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа /нарчд/ өгч байх	Нийт ажилчид	удаа	Үйл ажилгааны зардалд тусгах			2026 он	Компанийн ХАБЭА-н зааварчилгааг мөрдөх, Гамшигаас хамгаалах тухай хууль
10		Гамшгийн эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж эрхр бүхий байгууллагаар батлуулах	Ашиглалтын талбайн объектуудын хэмжээнд	удаа	Үйл ажилгааны зардалд тусгах			2026 он	
Дүн							-		
Нийт дүн							2,170,000		

6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувь нь ногоон байгууламжтай байна

Хүснэгт 6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг /мян/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ногоон байгууламж бий болгох	Мод тарих	Терминалын талбайд	Ширхэг	40	ҮАЗ		2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 4585:2016 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр
2	Өмнөх онуудад ашиглагдсан техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэсэн	Карьерийг тухайн газрын ландшафтай нь уялдуулан түрж тэгшлэх,	Захирамжаар олгогдсон давхцал, бусад маргаангүй Түгээмэл	га	22	Гэрээний дүнгээр		2026 он	

	БИЦУГ-н талбайг аймгийн Байгаль орчны газар хүлээлгэн өгөх/	хэлбэржүүлэх налуулах	тархацтай ашигт малтмалын талбай					тарих, арчлах MNS 6260 : 2020 Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал MNS5916:2008
Нийт дүн								

7. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх.

Төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ;

Хүснэгт 7. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6
1	Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Орон нутгийн уг үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад биет болон биет бус соёлын өвийг хадгалах, хамгаалах, хөгжүүлэх тал дээр тусламж үзүүлэх	Орон нутаг	1.000.0	2026	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд

8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Нефтийн бүтээгдэхүүнтэй байнга харицаж ажилладаг ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	ШТМ-тай шууд холбогдож ажилладаг ажилчдыг ХХХХ-ээр хангах	Терминалын талбайд ажиллах ажилчид	Иж бүрэн	1	1,500,000		2026 он	MNS 5002:2000, “ХАБЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS ISO 13688:2000, “ХАБЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” MNS 5390:2004, “ХАБЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
2	Нефтийн бүтээгдэхүүнтэй харьцаж байгаа ажиллагсад мэдлэг, дадлага туршлага хангалтгүй эсвэл анхаарал болгоомжгүйгээс ажлын хариуцлага алдах анхны тусламж үйлчилгээг мэдэхгүй улмаас эрүүл мэндээр хохирох	Ажилчдад нефтийн бүтээгдэхүүний физик, химийн шинж чанар, тэдгээртэй ажиллах, хадгалах, тээврийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны зохих мэдлэгийг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах	Нефтийн бүтээгдэхүүнтэй харицаж байгаа ажилчид	удаа	4	75.000	300.000	2026 он	
3		Нефтийн бүтээгдэхүүнтэй шууд харицаж ажилладаг ажилчдад хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох	Нефтийн бүтээгдэхүүнтэй харицдаг ажлын байрны хүмүүс	удаа	12	Үйл ажиллагааны зардлаар		2026 он	
4		Нефтийн бүтээгдэхүүн болон тэсэрж дэлбэрэх, гал гарах аюултай хэсэгт тамхи татах, ил гал гаргахыг хогилсон самбар тэмдэг тэмдгэлгээг байршуулах	Терминалын талбай	удаа	2	Үйл ажиллагааны зардлаар		2026	
5		Аюулын үед хэрэгжүүлэх	Терминалын талбай	удаа	1	Үйл ажиллагааны зардлаар		2026	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
		төлөвлөгөөг боловсруулж батлуулах							
6		Галын хор ашиглалт бүрэн бүтэн байдалд хяналтыг тогтмол явуулж албажуулах	Терминалын талбай	удаа	12	Үйл ажиллагааны зардлаар		2026	
7	Ажилчдын эрүүл мэнд,	Ажилчид ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, аюулгүй байдлын дүрмийг хатуу мөрдөх талаар танилцуулна	Ажилчдад	Тогтмол	1	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он	
8		Ажиллагсдыг зориулалтын иж бүрэн хувцас хэрэгслээр хангах	Ажилчдад	Жилд 1	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он		
9	Галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн осол аваарт өртөх	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж төвийн доторх хананд байршуулах	Терминалын талбай	Тогтмол	Үйл ажиллагааны хүрээнд		2026 он		
10		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Терминалын талбай	удаа	1	Үйл ажиллагааны хүрээнд			2026 он
Нийт дүн						1,800,000			

9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1		2	3	4	5	6	7	8
1	Ахуйн	Хог хаягдлыг тогтоосон журмын дагуу кодлон ангилж зайлуулах	Терминалын талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах				2026 он	БОУАӨЯ-ны сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль
2		Зам талбайн хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Терминалын талбай, талбайн гадна орчин	удаа	12	Дотоод зохион байгуулалтаар		2026 он	
3		Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, зориулалтын дагуу хадгалан тогтмол хугацаанд тээвэрлүүлж байх	Терминалын талбай	тн	12	150.0	1,800.0	2026 он	
4		Энгийн хог хаягдлын гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулан гэрээний хэрэгжилтийг биелүүлэх	Терминалын талбай	удаа	1	Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	
5		Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, зориулалтын дагуу хадгалан тогтмол хугацаанд тээвэрлүүлж байх	Терминалын талбай	удаа	тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	
6	Үйлдвэрийн	Ахуйн хэрэглээнээс үүсэх бохир усыг	Цэвэрлэх байгууламж	удаа	тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгах		2026 он	

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1		2	3	4	5	6	7	8
		хөрсөнд асгаж доройтуулахгүйн тулд сисптек систем буюу цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагааг тогтворжуулах							
7	Аюултай	Аюултай хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн зориулалтын цэг, савт цуглуулах	Терминалын талбайн аюултай хог хаягдлын цэг	удаа	тогтмол	Үйл ажиллагааны зардлаар		2026 он	
8		Машин техникийн засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тос масло шилжүүлэх гэрээг эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээлж шилжүүлж байх	Терминалын талбай	удаа	1	Гэрээний дүнгээр		2026 он	
9		Аюултай хог хаягдлын кодыг эрх бүхий байгууллагаас авах	Терминалын талбай	удаа	1	Үйл ажиллагааны зардлаар		2026 он	
10		Ариутгал халдваргүйжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагаах зохион байгуулах	Хог хаягдлын цэг болон өрөө тасалгаа	удаа	2	700.000	700.000	2026 он	
		Нийт дүн				2,500,000			

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Төсөв, мян. төг	Хууль, бодлого, стандарт
	1	2	3	4	5	6	7
	Агаарын чанар						
1	Хүхрийн исэл CO ₂ , NO ₂ , SO ₂ Тоос нийт (PM10, PM2.5) Дуу шуугиан хэмжээ	Төслийн талбайн хашаан дотор- 3 цэг	Улиралд нэг удаа	3 цэгт	Үйл ажиллагааны зардалд тусгана		Агаар мандлын сорьц авах ерөнхий шаардлага УСТ 3384-82 Агаарын чанар MNS 4585:2016
	Хөрс						
2	Агрохимийн үзүүлэлтүүд (ялзмаг, pH, EC2.5 dS/m, P2O5, K2O, CaCO3, NH4, NO2, NO3), Механик бүрэлдэхүүн (тоос, элс, шавар)	Терминалын талбайн мониторингийн цэгүүд	Жилд 2 удаа	4 цэгт	Үйл ажиллагааны зардалд тусгана		- MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” - MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
3	Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Co, Cr)	Хогийн цэг, машины зогсоол	Улиралд нэг удаа	2 цэгт			
	Усны чанар						
4	Усны химийн найрлага, хүнд металлын агууламж, бактериологи	Терминалын талбайн гүний худаг	Улиралд нэг удаа	1 цэгт	Үйл ажиллагааны зардалд тусгана		- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
5	Органик бохирдол	Цэвэрлэх байгууламж	Улиралд 1 удаа	4	Үйл ажиллагааны зардалд тусгана		- Хүрээлэн байгаа орчин. Усны чанар Хаягдал ус

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Төсөв, мян. төг	Хууль, бодлого, стандарт
	1	2	3	4	5	6	7
	Нийт дүн						

11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 4. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцах албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			... сар	... сар	... сар		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах	1,500.0	3 сар		11 сар	Гүйцэтгэх захирал	
3	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Үйл ажиллагааны зардалд	Тухай бүр			Гүйцэтгэх захирал	
4	Байгаль хамгаалах чиглэлээр шинийг санаачилсан ажилтанг шагнаж урамшуулах	Үйл ажиллагааны зардалд			12 сар	Гүйцэтгэх захирал	
5	Ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт гаргуулах		3 сар			Гүйцэтгэх захирал	
6	Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх.	-	Үйл ажиллагааны турш			Гүйцэтгэх захирал	
7	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсөвлөн, санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх, 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлэх.	Үйл ажиллагааны зардалд	Шаардлагатай үед			Гүйцэтгэх захирал	
8	Байгаль орчныг хамгаалах, осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт,	600.0	Үйл ажиллагааны явцад			Гүйцэтгэх захирал	

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцах албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			... сар	... сар	... сар		
	1	2	3	4	5	6	7
	сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.						
Нийт дүн			2,100.0				

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 5. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Сумын байгаль орчны газарт	Тайлагнах, мэдээлэл хүргүүлэх	Төслийн талбайд хийсэн ус, хөрс, агаарын чанарын шинжилгээний дүн	Улирал бүр	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	- Дорноговь аймгийн БОГ-т - Төрийн захиргааны төв байгууллага
Төсөл хэрэгжүүлэгч	Уулзалт, тайлагнах	БОМТ-нд тусгагдсан ажлууд, түүний хэрэгжилтийн талаар	Улирал бүр	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	- Төв оффис
Орон нутаг	Уулзалт	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлт, ирэх онд хийхээр төлөвлөсөн БОМТ-д тусгагдсан арга хэмжээ	11-12 сар			- Багийн төв
	Хуралд танилцуулах, хэлэлцүүлэх			Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	- Сумын төв
Төрийн захиргааны төв байгууллага	ТЖБОМТ-г хянуулах			Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны мэргэжилтэн	- Төрийн байгууллага
Нийт дүн			-			